

# **“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр

дугаар 01

Монгол улсын компанийн тухай хуулийн 60, 62, 65-р зүйлийн холбогдох заалтууд, тус компанийн 2022 оны 01 сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Дархан нэхий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 03 сарын 05-ний өдрийн 12 цагаас Дархан-Уул аймаг дахь “Дархан нэхий ХК-ийн “Гранд як” зочид буудлын 2 давхарын хурлын зааланд хуралдуулсугай.
2. ХЭХуралд доорхи асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

Үүнд:

1. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайланг танилцуулах
3. ТУЗ-ийн гишүүнийг сонгож батлах
4. ТУЗ-ийн төсөв батлах / цалин урамшууллын хэмжээг тогтоох/
5. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг батлах
6. Аудитын байгуулага сонгож батлах
7. Хөрөнгө татах тухай асуудал /төслийг/ хэлэлцэж батлах

3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг: 2022 оны 02 сарын 09-ний өдрөөр тогтоосугай.
4. Олон нийтэд зарлах өдрийг 2022 оны 01 сарын 25, мөн 2022 оны 02 сарын 09-ны өдрөөр тус тус тогтоосугай.
5. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2022 оны 02 сарын 26-ны өдрөөр дуусгавар болгосугай.
6. ХЭХурлын даргаар ТУЗ-ийн дарга /Э. Батсайхан/-ыг томилсугай.
7. Тооллогын комиссын даргаар Д. Ариунтуулыг, гишүүнээр Г. Эрдэнэтуяа, Б. Орхончимэг нарыг тус тус томилсугай.
8. ХЭХ-ыг зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн гишүүн Х. Золжаргалыг, гишүүнээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х. Нарантуяа нарыг тус тус томилсугай.
9. Хурлын бэлтгэл ажлыг компанийн тухай хуульд нийцүүлэх, ХЭ-дийн танилцах баримт бичиг, холбогдох материалыг хуульд заасан хугацаанд багтаан бүрдүүлж бэлтгэхийг ДНХК-ийн удирдлагын багт үүрэг болгосугай

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Э. БАТСАЙХАН

Х. НАРАНТУЯА